

МОНГОЛ ХЭЛНИЙ СОНСОХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ¹

Д.Отгонцэцэг
/Hankuk University of Foreign Studies/

Аливаа хэлийг заахад ярих (speaking), сонсох (listening), унших (reading), бичих (writing) зэрэг дөрвөн чухал чадварыг заавал эн тэнцүү эзэмшүүлэх учиртай. Монголд болон гадаад орнуудад гадаад хүнд монгол хэл зааж байгаа байдлыг ажиглахад унших болон бичих чадварыг илүүтэй хөгжүүлээд сонсох чадварыг харьцангуй бага заах юм уу ерөөсөө ор орхигдуулах тал харагдаж байна. Гэтэл аливаа хэлийг сурах суурь нь ерөөсөө дуудах, сонсох чадварыг эхнээс нь сайн хөгжүүлэх явдал юм. Нэг талаас бичсэн юмыг харж уншиж ойлгож болно, ярьсан зүйлийг заавал чихээр сонсож ойлгоно. Нөгөө талаас хүний бичсэн зүйлийг нүдээр харж уншсаныг чихээр сонсож ойлгож болно. Дээрх дөрвөн чадварын харьцаа ийм холбоотой байдаг. Монгол хэлийг оюутнуудад заахдаа тэдний хэрхэн сонсож, дуудах, ярихыг анхааралтай ажиглаж байх хэрэгтэй. Дуудлага сайн бол багшид юу хэлэх гээд байгаа нь тун ойлгомжтой болно. Оюутнууд хэлний өргөлт болон аялгыг эхнээс нь зөв дуудаж сурах учиртай. Үүнд эхний ээлжинд уйгагүй олон удаа даган дуурайлгаж дуудуулах маш үр ашигтай байдаг.

Унших бичих хоёр нь бичгээр байж, хэвлэмэл дүрээр илэрдэг бол ярих, сонсох хоёр нь агаараар дамжиж илэрдэг онцлогтой. Хүн төрөлхтний түүхэнд хүний харилцааны аман яриа нь анхдагч юм уу, бичгийн харьцаа нь анхдагч юм уу гэдэг асуудал байдаг. Чи хүүхэд байхдаа хамгийн түрүүн алийг нь хэрэглэсэн бэ? Бичсэн үү, ярьсан уу? Хэрвээ ээждээ мээмээ хөхөө гэж бичиж өгсөн бол “чи хамгийн мундаг хүүхэд” байх нь. Мэдээж ярих нь анхдагч байсан байж таараа. Тийм учраас ганц монгол хэл биш аливаа хэлийг гадаад хэл болгон заахдаа сонсох чадварыг хөгжүүлэхийг эхнээс нь марталгүй, алгасалгүй, орхилгүй, уйгагүй сургах ёстой. Гэхдээ бичих, уншихыг ч гэсэн мэдээж орхигдуулж болохгүй нь хэнд ч ойлгомжтой зүйл билээ.

Монгол хэлний хувьд ямар байна вэ? Монгол хэлийг заахдаа бид голдуу ярих буюу ярианы хэл, бичих буюу бичгийн хэл, унших буюу уншлага гэсэн үндсэн гурван хичээлийг заадаг ч гэсэн сонсох чадварыг хөгжүүлэх талыг орхигдуулдаг тухай дээр дурдсан билээ. Энэ бол монгол хэлийг ч биш аль ч гадаад хэлийг заахад гадаад дотоодод нийтлэг байдаг дутагдал байна. Гэхдээ монгол хэлийг заахад хэдийгээр сургалтын хөтөлбөрөөр тус тус заасан ч гэсэн аль ч хэсгийг яс зааглан заахад түвэгтэй бөгөөд дээрх дөрвөн чадвар нь бие биедээ заавал уусан шингэж байдаг үзэгдэл юм. Тийм учраас нэг ангид олон төрлийн хичээлийг олон багш заах нь хэрвээ дээрх дөрвөн чадварыг нарийн салгаж бас шингээж өгсөн хэлний түвшинд тохирсон сайн сурах бичиг байхгүй тохиолдолд нэг талаас оюутанд маш түвэгтэй байдал үүсдэг. Багш нар хоорондын харилцан хамаарал байхгүй бол

¹ This work supported by the Hankuk University of Foreign Studies Research Fund of 2015.

зарим нь энгийн зүйл зааж байхад зарим нь ахисан түвшний хэтэрхий хүнд зүйл зааж байх жишээгээр зөрчил бий болж байдаг. Бидний ажигласанаар хэдий чинээ сонсох чадвар муу байна төдий чинээ зөв бичгийн дүрмийн болон бичлэгийн алдаа байнга хийж байдаг. Энэ бол сонсох суурь чадвар дутуу тавигдсанаас болж байгаа хэрэг юм. Өөрөөр хэлбэл монгол хэлний авиа болон гийгүүлэгчийн ялгааг бүрэн олж, дуудаж сураагүй, ялгах чадваргүй байхад нь дараагийн хичээлийг зааснаас болж суралцагч маш муу дуудлагатай үлдэх юм уу муу унших, бас буруу сонсголттой хэвээрээ үлдэх нь байдаг байна.

Монгол хэлний хувьд эрс тэс ялгаатай эр эм саармаг эгшиг олонтой, урт богино болон хос олон эгшигтэй, ойролцоо дуудлагатай хатуу зөөлөн гийгүүлэгч авиа нэлээдгүй байдаг зэрэг нь эхлэн суралцагчид авианы дуудах чадварыг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай болдог бөгөөд энэ нь гагцхүү сурах бичигт чухам хэрхэн дуудах, ялгааг яаж гаргах, дасгал их бага хэр зэрэг байх, дагаж дууриах бичлэг байгаа эсэх зэрэг түүнийг зохиогчоос хэрхэн боловсруулснаас ихээхэн шалтгаалдаг юм. Гадаад хүнд зориулсан монгол хэлний сурах бичиг, гарын авлагад монгол хэлний авиа зүйн талаар гарсан ном сурах бичиг олон байдаг боловч гадаад хүнд монгол хэлний дуудлагыг заахад тусгайлан зориулсан гарын авлага нэн ховор байдаг. Бид гадаад хүнд зориулсан маш олон сурах бичгийг зориуд ажиглан үзвэл авиа дуудлагын дасгал нь хэт бага юм уу зарим тохиолдолд бие биенээ дууриасан байдалтай байгаа нь ажиглагдаж байна.

Орчин цагийн монгол хэлний бараг анхных болох МУИС-ийн багш нарын зохиосон “Монгол хэл сурах бичиг” номын нэгдүгээр хичээлд Цагаан толгой болон эгшиг, гийгүүлэгч үсэг, я-гийн төрлийн үе үсэг, болон зарим үсгийн тайлбар оруулж авианы дасгал гэсэн 8 дасгалтай товч хэсэг оруулсан байдаг. Энэхүү хэсэг нь н болон нг, о, болон ө, у болон ү, ж болон з, зэрэг гийгүүлэгчийг чухам яаж дуудахыг өгүүлэх эрхтний байрлалыг харуулсан зурагтай бөгөөд суралцагч нарт чухам яаж дуудахыг үзүүлснээрээ ач холбогдолтой болсон ажээ. Үүнээс хойшхи хэвлэгдсэн гарсан гадаад дотоодын их сургуулиудад хэрэглэгддэг сурах бичгүүд²-ийг ажиглан үзвэл голдуу авианы дуудлага болон байрлалыг маш товч үзүүлж голдуу давтамж ихтэй цөөхөн жишээ баримтаар үзүүлж ирсэн бөгөөд авианы дуудлага дасгалыг гол болгож анхаараагүй нь харагдаж байна.

Харин судлаач Ч.Баттулга, М.Лайхо нарын бичсэн “Халх авианы дуудлага” хэмээх хуурцагтай ном³ бол дан авиа сонсгол, хэлэхийн дасгал хийж, монгол хэлний төрөл бүрийн авиа, гийгүүлэгч зэргийн тогтолцоог ойлгож зөв дуудаж сурахад зориулсан тусгай сурах бичиг болсон байна.

Англи болон бусад хэлний авиа дуудлагын чадварыг сайжруулахад зориулсан сурах бичиг болон гарын авлагыг үзвэл тухайн хэлний хоорондоо төстэй авиануудын

⁰ Л.Лхагва, Ж.Лувсандорж, “Учитесь говорить по монгольски”, 1978, Уб., Jaroslav Vacek, Dz.Luvsandordz, Choi.Luvsandzav, “Ucebnice Mongolstiny Hovorovy styl”, 1979, Praha, С.Галсан, И.А.Грабарь, Учебник монгольского языка для иностранцев”, 1989, Уб., Ц.Тэрбиш, “Монгол хэл өөрөө сур”, 1994, Уб., Л.Г.Скородумова, “Учебник Монгольского Языка”, 1996, Уб., Ц.Сүхбаатар, “Монгол хэл сурах бичиг”, 1995, Уб., ; Ц.Шагдарсүрэн, “Орчин цагийн монгол хэлний сурах бичиг”, 1999, Уб., ; Ч.Чимэгбаатар, М.Саранцэцэг, “Монгол хэл сурах бичиг”, 2000, Уб., Г.Лувсан, “Монгол хэлний сурах бичиг” (Lehrbucher Mongolischen Sprache), 2002, Уб., Г.Ариунжаргал, “Монгол хэлний зөв бичих зүйн дүрэм ба дасгал”, 2008, Уб., А.Мөнхцэцэг, Х.Дэлгэрмаа, “Goldenkey to Mongolian”, 2006, Уб., ; Ж.Бат-Ирээдүй, “Монгол хэлний хэл зүйн сан”, 2008, Уб., Х.Дэлгэрмаа нар, “Монголоор ярьж сурицаа”, 2009, Токио, Д.Баттуул, “Монгол хэлний яриа ба сорил”, 2009, Уб.,

³ Tsh.Battulga, Mika Laiho, A students guide to Khalkha Mongolian pronunciation”, Уб., 1999, Edited by J.Bat-Ireedui

дуудлагыг харьцуулан үзүүлж хийсэн нь олон байдаг бөгөөд эл ном ч гэсэн монгол хэлний зарим төсөөтэй дуудагддаг эгшиг болон гийгүүлэгч авиаг харьцуулан үзүүлж хийсэн нь суралцагч нарт тухай авиануудын чухам ялгааг нарийн сонсож дараа нь хэлж дадахад чухал ач холбогдолтой болсон байна. Тухайлбал, монгол хэлний эр эгшиг буюу back vowels а, о, у, эм эгшиг буюу front vowels ө, ү, э, саармаг буюу neutral vowel и, зэргийг я, ё, е тэй зэрэгцүүлэн үзүүлж, эр эгшигийг урт эгшигтэй нь хамт *ав аав, арц аарц, зах заах, хана хаана, давуу даавуу, хол хоол, бол боол, тос тоос, бодол боодол, зогсох зогсоох, ул уул, хур хуур, тул туул, зун зуун, будах буудах, үл үүл, үр үүр, нүх нүүх, дүрэх дүүрэх, шүлэг шүүлэг*, гэх мэтээр тус бүр бие даасан утга бүхий үгсийг жишээгээр сонгож авсан байна. Мөн уу, үү, оо өө, урт эгшгүүдийг тус бүрт эсрэгцүүлэн жишээгээр үзүүлж хэрхэн хэлэхийг үгээр тайлбарлаж, зургаар үзүүлсэн нь суралцагч эхнээсээ авиа зүйн зөв дуудлагад суралцаж зүгширэхэд маш чухал ач холбогдолтой болжээ. Цаашилбал авиан зүйн даган дууриах дасгалд зориулан хамгийн зохистой өгүүлбэрүүдийг сонгож хийсэн нь өгүүлбэрийн түвшинд авиаг зөв дуудах дадал олгоход их тустай болжээ. Жишээлбэл, *Амар ваар авав, Ах сар харав, Болд хоол зооглов, Олон том ном байна, Хулан хуур хуурдав, Туул уул руу явсан, Үүл нүүв, Үр хүүхэд өсөв, Дүү цэцэг түүв, Ах дуу дууллаа, Өөр өөр өд байна, Хөл хөөрцөг болов, Зөв тоолж сур, Сайхан боо, Эрэг дээр элээ хэрээ галуу гурав, Миний ээж дээл эсгэлээ* гэх мэт энгийн ойлгомжтой богино өгүүлбэрүүдийг түүвэрлэн сонгож хийсэн нь бусад гадаад хэлний ижил төстэй авиа болон гийгүүлэгчийг зэрэгцүүлэн үзүүлдэг туршлагаас суралцсан гэж үзэж болохоор байна. Тухайлбал англи хэлний “Pronunciation Pairs”⁴ гэдэг ном бол яг ийм зарчмаар хийсэн бөгөөд ам, хэл, өгүүлэхүйн эрхтний булчин хэрхэн хөдөлж байгааг зургаар үзүүлж, дадлага, яриа, өргөлт, зөв бичлэг гэсэн дэс дарааллаар хийсэн байдаг юм. Цаашид манай хэлний мэргэжилтэнүүд гадаад оюутанд зориулсан монгол хэлний авиа дуудлагад сургах тусгай сурах бичиг даруй зохиох шаардлагатай байгаа юм.

Ер нь авианы дасгалын үгийг сонгохдоо аль болох утга илэрхийлэх үг, хэллэг сонгох нь зөв бөгөөд харин тухайн үед суралцагчид утгыг тайлбарлах гэж яарах хэрэггүй юм. Багш нарт ажиглагддаг нэг дутагдал бол утгыг тайлбарлах гэж хэт яарах юм уу мэрийх явдал байдаг бөгөөд эхний удаад утга тийм их чухал биш, харин утга үл үүсгэх эгшиг гийгүүлэгч авианы нийлэмжээс аль болох татгалзах хэрэгтэй гэж үзэлтэй. Үг хэллэгийн утгыг тайлбарлах гэж хэт яарснаас сонсогч дуудлагад биш утгад шүтэж анхаарал нь өөр зүйл сарниж, сонсгол, дуудлагадаа анхаарахаа больдог тал бий.

Авиа дуудлагад сургах өөр нэг чухал арга бол сайн сонсох. Мэдээж оюутанд багш хамгийн анхны дуудлага заана, харин багшийн авиа дуудлагыг байнга сонсоноос болж түүнд дасаж бусад хүний яриаг ойлгохгүй болох явдал байдаг. Учир нь багшийн яриа, дуудлага бол чухам нэг л төрлийнх бөгөөд хэдэн түмэн янзын дуудлага байдаг учраас оюутан аль болох олон янзаар сонсож сурах учиртай. Үүний тул аль болох өөр хоолой, өөр хүн хольж сонсох хэрэгтэй бөгөөд үүнд си ди болон бусад бичлэг тавьж сонсох нь чухал ач холбогдолтой юм.

Авиа дуудлага, сонсох чадварыг хөгжүүлэхэд хэлний түвшин чухал үүрэгтэй бөгөөд эхлэн суралцагч нарт хэлний төрөл бүрийн авиа, гийгүүлэгчийн дуудлага, сонсгол чухал байдаг бол ахисан түвшний суралцагч нарт бүхэл үг, хэллэг, мөн эхийн дуудлага нэн чухал бөгөөд үүнийг хөгжүүлэхэд тусгай сурах бичиг гарын авлага нэн чухал шаардлагатай. Чухам ямар сэдэвтэй эх байна вэ гэдгээс

⁴ Ann Baker, Sharon Goldstein, “Pronunciation Pairs” CUP, 1995

шалтгаалан тухайн уншигчийн дуу хоолой, өнгө тавил өөрчлөгдөж байдаг болохыг эндээс анзаарч болно. Монгол хэлний хувьд профессор К.Окада, Ж.Бат-Ирээдүй нарын хамтран хийсэн “Монгол хэлний сонсох дадлага I,II” ном энэ чиглэлийн маш чухал гарын авлага болж байна. Энэ номын зохиомжийг ажиглавал уран уншигч Р.Равдангийн “Үхэр монголын уур хилэн” 2 си ди бүхий монголын богино өгүүллэг, яруу найргийн бичлэг дээр суурилан гурван үе шаттайгаар сонсох, сонсогч өөрийнхөө зөв бурууг шалгаж болох боломжтой дасгал зэргийг оруулж өгсөн нь тун чухал арга болжээ. Ийм төрлийн сурах бичиг гарын авлага улам олон хүний дуу хоолойгоор, улам олон янз, хэв маягаар гарах учиртай байх.

Ийнхүү монгол хэлний авиа дуудлага, сонсох чадварыг хөгжүүлэх, сургахад ач холбогдолтой байж болох зарим цөөн санаа оноог энэ өгүүлэлд дурдлаа, цаашид монгол хэлний авиа дуудлагыг заах, аргыг хөгжүүлэх, энэ чиглэлээр сурах бичиг гарын авлага хэрхэн хийх санааг өргөжүүлэхэд энэ чиглэлээр олон зүйл судалгаа шинжилгээ хийх шаардлагатай байгааг дурдалтай.

Summary

When we teach Mongolian we need to be sure that our students can be understood when they speak. They need to be able to say what they want to say. This means that their pronunciation should be at least adequate for that purpose. Students need to use rhythm and stress correctly if they are to be understood. Students need to be able to recognise intonation – at the very least they need to recognise whether the tune of someone’s voice suggests that the speaker is sure or uncertain. They need to understand the relationship between pitch and intonation. One issue that confronts us in the teaching of pronunciation is that of accent. In other words, how important is it for our students to sound like native speakers of the language. The teaching of pronunciation should, therefore, aim to give students communicative efficiency.

Keywords: pronunciation, sounds, rhythm, stress, intonation, pitch, listening.

НОМ ЗҮЙ

1. Ж.Бат-Ирээдүй, К.Окада, (2009) “Монгол хэлний сонсох дадлага I”, Уб.,
2. Ж.Бат-Ирээдүй, К.Окада, (2009) “Монгол хэлний сонсох дадлага II”, Уб.,
3. Ш.Баттөгс, “Монгол хэлний хэл зүйн тайлбар, дасгалууд”, 2011, Уб.,
4. Хамтын, (2015) “Монгол хэлний түвшин тогтоох сорилго”, Уб.,
5. Ch.Battulga, Mika Laiho, (1999) “A Student guide to Khalkha Mongolian Pronunciation”,
6. Ц.Тэрбиш, “Монгол хэл өөрөө сур” (Learn Mongolian yourself), Уб., 1994
7. Ann Baker, Sharon Goldstein, “Pronunciation Pairs”, CUP, 1990,
8. Barry Sesnan, (2003) “How to Teach English”, Oxford University Press,
9. David Cross, “A Practical Handbook of Language Teaching”, Phoenix ELT, 1995
10. Jeremy Harmer, “The Practice of English Language Teaching”, Longman, 1992